

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/1/СТА-ТӨХК

## Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл .....	8
2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал .....	11
3.1 Зардлын данстай холбоотой асуудал .....	11
3.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал .....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар .....	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	15
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.5 Аудит хийсэн 2018 оны зорилтот түвшингийн үзүүлэлтийн биелэлт .....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт .....	20



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР  
ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
С.БЯМБААХҮҮ ТАНАА

2019.03.15 № 06/475  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### **Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал С.Бямбаахүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 3-наас 3 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Нийслэл аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер Б.Хөхөө, аудитор Д.Ариунбулган, ахлах шинжээч Д.Чулуунбаатар, аудиторын туслах Ц.Гантуяа, аудиторын туслах Д.Доржпүрэв нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь 2018 оны санхүүгийн тайланг “Нийслэл аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 01/46 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн боловч төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацааг 7 хоног хоцроосон.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь “Найдвартай эрчим хүч, Шинэ технологи, Өөдрөг амьдрал” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 5 дугаар тогтоолын хавсралтад үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх
- Цахилгаан, дулааны эрчим хүчийг дамжуулах, түгээх, борлуулах

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Компаний тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын тухай
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд дээрх бодлого журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Тус станц нь ТУЗ-ийн 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 6 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлдээ мөрдөн ажиллаж байна. Гэвч энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар" мөн Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал"-ын дагуу Нягтлан бодох бүртгэлийн горим, дансдын нийтлэг бичилт, жишиг жагсаалт, нэгдсэн кодчилал, зэрэгт орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэгдээгүй байна. 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдөр “Си Эс Ай Аудит” ХХК-тай Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн зохих өөрчлөлтийг оруулах тухай А18/68 дугаар ажлын гэрээ хийсэн байна. Гэрээт ажил цаг хугацаандаа дуусаагүй бөгөөд гүйцэтгэгчийн хүсэлтээр 2018 оны 8 дугаар сарын 1-ний өдөр 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгөхөөр нэмэлт гэрээ хийсэн боловч одоог хүртэл гэрээт ажлыг дуусгаагүй, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хүлээлгэж өгөөгүй байна.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “UNICUS” програмыг санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянан үзэхэд тайлант хугацаанд 6 чиглэлийн хяналтын ажлыг хийж зөвлөмж өгсөн байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардалын нэг хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллагын хувьд тайлант үеийн үйл ажиллагаанд нөлөөлж чадахуйц үзүүлэлт гэж гэж үзэн материаллаг байдлын суурь болгон сонголоо.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны нийт зардал 225,134.0 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 225.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт тус байгууллагын хувьд харьцангуй бага эрсдэлтэй гэж үзэн материаллаг байдлын түвшинг нэг хувиар сонгосон болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.



Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Тайлант хугацаанд тус станц Өмчийн өөрчлөлтийн тайланд 6,976.1 сая төгрөгийн дүнг нэмж тусгасан ба энэ нь Улсын бүртгэлийн гэрчилгээний өмчийн дүн гээс 6,976.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн тул залруулга хийсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	13.3	
2	Албан шаардлага өгсөн	1	85.0	
	Дүн	4	98.3	

#### 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагад танилцуулж Аудитын үр дүнг танилцуулсан талаарх мэдээлэл Г301 маягтаар баталгаажууллаа.

Дансны авлагын тайлант оны эхний үлдэгдэл 303.5 сая, эцсийн үлдэгдэл 1,151.2 сая төгрөгт хүрч 847.7 сая төгрөгөөр, дансны өглөг тайлант оны эхний үлдэгдэл 124.7 сая, эцсийн үлдэгдэл 1,159.4 сая төгрөгт хүрч 1,034.7 төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоотой 3.5 сая төгрөгийн авлага, 81.5 сая төгрөгийн өглөг нийт 85.0 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооцоо нийлээгүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дээрх зөрчилтэй асуудалд албан шаардлага өгсөн болно.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал нь цалин, хөлс тогтоож байгаа хууль, эрх зүйн актыг нарийвчлан шалгах, мөн хамтын гэрээнд заагдсан нэг удаагийн тэтгэмж, урамшуулалтай

холбоотой заалтуудыг зохих хууль, дүрэм, журам заавартай нийцэж байгаа эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Тус станц үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг 2016 онд “Үндэсний реалти” ХХК-аар хийлгэсэн байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 11 дүгээр сарын А-5/4279 албан бичгийг үндэслэн тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй байна.

## **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны батлагдсан зорилтот түвшинг гүйцэтгэлтэй нь харьцуулж үзвэл:

Боловсруулсан цахилгаан эрчим хүч 158,0 сая квт/ц үйлдвэрлэхээс 161,4 сая квт/ц үйлдвэрлэж төлөвлөгөөг 102,1 хувиар, дотоод хэрэглээний цахилгаан эрчим хүч 21,8 сая квт/ц үйлдвэрлэхээс 21,3 сая квт/ц үйлдвэрлэж төлөвлөгөөг 97,8 хувиар тус тус биелүүлсэн. Цахилгаан эрчим хүч түгээлт 136,2 сая квт/ц үйлдвэрлэхээс 140,1 сая квт/ц буюу 102,8 хувиар, дулааны эрчим хүч түгээлт 190,5 мян.Гкал үйлдвэрлэхээс 201,1 мян.Гкал буюу 105,6 хувиар үйлдвэрлэлийг тус тус давуулан биелүүлсэн байна.

Зорилтот түвшингийн төлөвлөгөөгөөр цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого 20,379.9 сая, дулааны эрчим хүчний орлого 2,533.0 сая, үйл ажиллагааны бус орлого 180.4 сая төгрөгөөр тус тус батлагдсанаас гүйцэтгэлээр цахилгаан эрчим хүчний орлого 19,579.2 сая төгрөг буюу 96,1 хувиар, дулааны эрчим хүчний орлого 2,617.1 сая төгрөг буюу 103,3 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 346.4 сая төгрөг буюу 192,0 хувиар тус тус биелсэн байна. Үүнээс цахилгаан эрчим хүчний орлого 800,7 сая төгрөгөөр тасарч харин дулааны эрчим хүчний орлого 84,1 сая, туслах үйл ажиллагааны орлого 166,0 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлж нийт дүнгээр 550,6 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасалджээ. Энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооноос тарифын зохицуулалт хийгээгүйтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд 23,093.3 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөснөөс 22,768.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 324.7 сая төгрөгөөр хэмнэсэн боловч дараах зардлууд хэтэрсэн байна. Үүнд:

1. Түүхий эд материалын зардал 9.3 сая
2. Шатахууны зардал 12.8 сая
3. Урсгал засварын зардал 59.8 сая
4. Хангамжийн материал, конторын хангамжийн зардал 0,6 сая
5. Худалдан авсан цахилгаан 43.7 сая
6. Ашиглалтын зардал 8.8 сая
7. Гүйцэтгэх удирдлагын зардал 11.0 сая
8. Диспетчерийн зардал 2.5 сая
9. Зохицуулалтын үйлчилгээний хөлс 6.2 сая
10. Гадны үйлчилгээний хөлс 61.8 сая
11. Үйл ажиллагааны бусад зардал 8.9 сая
12. Үйл ажиллагааны бус бусад зардал 216.7 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн <http://www.tpp2.mn> цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж байна. Тайлант хугацаанд шилэн дансны стандартыг баримтлан шилэн дансны сайтад мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв оруулж дараах мэдээг хүргэсэн байна. Үүнд: Бүтэн жилээр оруулах мэдээлэл хэсэгт 2 удаа, тухай бүр оруулах мэдээлэл хэсэгт 57 удаа нийт 59 мэдээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Тайлант жилд шилэн дансны цахим хуудсанд нийт 62 төрлийн мэдээллийг байршуулахаас 59 мэдээ буюу 95,1 хувийг цаг хугацаанд нь оруулж үлдэх 3 мэдээ буюу 4,9 хувийг хугацаа хожимдуулан байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 100 хувь хэрэгжүүлж биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБООС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардлын данстай холбоотой асуудал**

##### 3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд зарцуулсан стандарт ба стандарт бус нүүрсний өртөгт 3.3 сая төгрөгийг илүү тооцоолсон байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3. “жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан болон тайлант үеийн үр дүн буруу илэрхийлэгдэх

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын 2.25-д “Шинж чанар ашиглах зориулалт нь адилхан бараа материалын хувьд аж ахуйн нэгж өртгийн адилхан аргыг хэрэглэнэ” гэж заасны дагуу нүүрсийг зарлагадахдаа стандартын болон стандартын бус нүүрсийг нэгтгэн тооцоолж дундаж өртгийн аргыг хэрэглэж санхүүгийн тайландаа тусгах

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

#### **3.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

##### 3.2.1 Илрүүлэлт:

Жилийн эцсийн байдлаар тус станцын кассын данс кассын үйл ажиллагааны журамд заагдсан үлдэгдлээс 9.9 сая төгрөгийн илүү үлдэгдэлтэй байна. Энэ нь Мөнгөн кассын үйл

ажиллагааны журам 7.3.7 “*кассын тухайн өдрийн үлдээдэл 10 сая төгрөгнөөс дээш байж болохгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд илүүдлийг харилцах дансанд тушаана*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Өмч хөрөнгө шамшигдах, үрэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Кассын үйл ажиллагааны журмын дагуу хязгаараас хэтэрсэн үлдэгдлийг харилцах дансанд тушааж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

3.3.1 Илрүүлэлт:

Тус станцын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, 2014 оны 249 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар” мөн Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал”-ын дагуу Нягтлан бодох бүртгэлийн горим, дансдын нийтлэг бичилт, жишиг жагсаалт, нэгдсэн кодчилал, зэрэгт орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэгдээгүй байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.2.2. “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд алдаа гарах, буруу илэрхийлэгдэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Зохих өөрчлөлтийг хийж шинэчилсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	195,595,940.20	344,745,471.23
1.1.2	Дансны авлага	303,543,061.72	1,151,249,165.71
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	22,431,056.13	13,089,880.27
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	972,950,806.06	1,121,413,897.53
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	200,821,104.24	29,186,868.51
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,695,341,968.35</b>	<b>2,659,685,283.25</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	35,412,286,281.94	36,069,239,051.30
1.2.2	Биет бус хөрөнгө	12,261,507.18	18,804,532,733.89
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9			
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>35,424,547,789.12</b>	<b>54,873,771,785.19</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,119,889,757.47</b>	<b>57,533,457,068.44</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	124,759,045.22	1,159,394,634.67
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	911,106.48	80,266,418.95
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	16,768,000.00	-

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12			
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>142,438,151.70</b>	<b>1,239,661,053.62</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	606,923,040.11	565,039,976.05
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5			
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>606,923,040.11</b>	<b>565,039,976.05</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>749,361,191.81</b>	<b>1,804,701,029.67</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	1,821,344,502.78	1,821,344,502.78
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,150,810,461.72	10,792,098,755.60
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	24,169,491,363.84	44,179,359,216.56
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(771,117,762.68)	(1,064,046,436.17)
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>36,370,528,565.66</b>	<b>55,728,756,038.77</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>37,119,889,757.47</b>	<b>57,533,457,068.44</b>

#### 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>20,863,420,022.13</b>	<b>22,196,318,452.54</b>
2	Борлуулалтын өртөг	18,316,298,834.47	20,032,452,717.65
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>2,547,121,187.66</b>	<b>2,163,865,734.89</b>
4	Түрээсийн орлого	10,167,524.68	23,460,799.96
5	Хүүгийн орлого	23,966,857.26	27,734,753.54
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	230,058,804.80	295,179,267.07
9	Борлуулалт, маркетингийн зардал	47,060,877.19	25,305,270.18
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,365,577,100.70	2,441,518,241.56
11	Санхүүгийн зардал	14,866,801.65	14,128,514.53
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,455.98)	12,369.11
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(11,267,054.78)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	(289,315,332.77)	(241,182,277.89)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>94,489,806.11</b>	<b>(223,148,434.37)</b>
19	Орлогын татварын зардал	2,396,685.72	2773,475.35
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>92,093,120.39</b>	<b>(225,921,909.72)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>92,093,120.39</b>	<b>(225,921,909.72)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>		
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		



### 4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,821,344,502.78	11,195,450,723.4	6,976,191,040.00	(765,887,394.70)	19,227,098,871.43
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(97,323,488.37)	(358,711,706.12)
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-	92,093,120.39	92,093,120.39
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	17,193,300,323.80	-	17,193,300,323.80
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(44,640,261.60)	-	-	(44,640,261.60)
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,821,344,502.78	11,150,810,461.72	24,169,491,363.84	(771,117,762.68)	36,370,528,565.66
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(67,006,763.77)	(67,006,763.77)
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(225,921,909.72)	(225,921,909.72)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	20,009,867,852.72	-	20,009,867,852.72
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(358,711,706.12)	-	-	(358,711,706.12)
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,821,344,502.78	10,792,098,755.60	44,179,359,216.56	(1,064,046,436.17)	55,728,756,038.77

#### 4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>20,770,215,096.69</b>	<b>20,249,316,754.69</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	20,123,667,271.61	19,848,706,584.30
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	73,771,669.65	67,388,157.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	572,776,155.43	333,222,013.39
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>20,592,118,487.62</b>	<b>19,510,642,950.26</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	5,670,764,576.21	5,915,685,468.26
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,441,675,918.20	1,690,780,323.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,522,603,580.70	2,201,948,816.60
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,231,705,233.55	423,047,459.45
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,344,239,841.69	7,033,679,353.14
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,897,720,763.94	1,520,718,745.07
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	11,958,568.00	11,996,431.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	471,450,005.33	712,786,353.01
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>178,096,609.07</b>	<b>738,673,804.43</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>23,966,857.26</b>	<b>27,734,753.54</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	23,966,857.26	27,734,753.54
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8			
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>172,245,333.00</b>	<b>579,951,599.10</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	172,245,333.00	579,951,599.10
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6			

2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(148,278,475.74)</b>	<b>(552,216,845.56)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>8,570.60</b>	<b>14,679.41</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад	8,570.60	14,679.41
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>160,469,315.25</b>	<b>27,322,107.25</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	18,492,538.67	28,110,496.95
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	141,963,750.00	9,209,300.00
3.2.5			
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(160,460,744.65)</b>	<b>(37,307,427.84)</b>
4	Валютын ханшийн зөрүү		
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(130,642,611.32)</b>	<b>149,149,531.03</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>326,238,551.52</b>	<b>195,595,940.20</b>
7	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>195,595,940.20</b>	<b>344,745,471.23</b>

#### 4.5 Аудит хийсэн 2018 оны зорилтот түвшингийн үзүүлэлтийн биелэлт

(сая төгрөгөөр)

№	Үзүүлэлтүүд	х.н	2018 оны 4-р улирал		зөрүү		
			төлөвлөгөө	гүйцэтгэл	Хувь	Биетээр	
1	Боловсруулсан ЦЭХ	саякВт.ц	158.0	161.4	102.2	3.4	
2	ДХ ЦЭХ	биетээр	саякВт.ц	21.8	21.3	97.7	-0.5
		Хувиар	хувь	13.8	13.2	95.6	-0.6
3	Эрчимхүчтүгээлт	Цахилгаан	саякВт.ц	136.2	140.1	102.9	3.9
		Дулаан	Мян.Гкал	190.5	201.1	105.6	10.6
4	Нийторлого	сая.төг	23,093.3	22,542.7	97.6	-550.6	
	Үүнээс: Цэвэрборлуулалт	сая.төг	22,912.9	22,196.3	96.9	-716.6	
5	Нийтзардал	сая.төг	23,093.3	22,768.6	98.6	-324.7	
	Үүнээс: Удирдлагынзардал	сая.төг	248.7	257.7	103.6	9.0	
6	Татварынөмнөхшиг / алдагдал /	сая.төг	-	-225.9	-	-225.9	
7	Цэвэрашиг / алдагдал /	сая.төг	-	-225.9	-	-225.9	
8	Төрийнөмчийнногдолашиг	сая.төг	-	9.2	-	9.2	
9	Борлуулалтын 1 төг-т ногдохзардал	төг	1.0	1.0	100.0	0.0	
10	Авлага	сая.төг	457.5	1,164.3	254.5	706.8	
11	Өглөг	сая.төг	1,095.2	1,804.7	164.8	709.5	
	Үүнээс: Богинохугацаатөглөг	сая.төг	488.3	1,239.7	253.9	751.4	
12	Ихзасвар, ТЗБАХ, хөрөнгөоруулалт	сая.төг	2,280.6	2,003.0	87.8	-277.6	
13	Жишмэлтүлшнийзарцуулалт	ЦЭХ	гр/квтц	646.5	652.5	100.9	6.0
		ДЭХ	кг/Гкал	202.2	201.7	99.8	-0.5
14	Аваар, саатал	тоо	-	2	-	2	

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо:

2019.03.14

Аудитын нэр:

Санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2019/1/СТА-ТӨХК

Шалгагдсан байгууллагын нэр:

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК

Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Дансны авлагын тайлант оны эхний үлдэгдэл 303.5 сая, эцсийн үлдэгдэл 1,151.2 сая төгрөгт хүрч 847.7 сая төгрөгөөр, дансны өглөг тайлант оны эхний үлдэгдэл 124.7 сая, эцсийн үлдэгдэл 1,159.4 сая төгрөгт хүрч 1,034.7 төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоотой 3.5 сая төгрөгийн авлага, 81.5 сая төгрөгийн өглөг нийт 85.0 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооцоо нийлээгүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.	85.0	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	С.Бямбаа хүү Б.Даваад улам
2	Тайлант хугацаанд зарцуулсан стандарт ба стандарт бус нүүрсний өртөгт 3.3 сая төгрөгийг илүү тооцоолсон байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3. “жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.	3.4	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	С.Бямбаа хүү Б.Даваад улам
3	Жилийн эцсийн байдлаар тус станцын кассын данс кассын үйл ажиллагааны журамд заасан үлдэгдлээс 9.9 сая төгрөгийн илүү үлдэгдэлтэй байна. Энэ нь Мөнгөн кассын үйл ажиллагааны журам 7.3.7 “кассын тухайн өдрийн үлдээдэл 10 сая төгрөгнөөс дээш байж болохгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд илүүдлийг харилцах дансанд тушаана” гэсэнтэй нийцэхгүй байна.	9.9	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	С.Бямбаа хүү Б.Даваад улам
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь зохих хууль, дүрэм журам зааврын дагуу шинэчлэгдээгүй байна.		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	С.Бямбаа хүү Б.Даваад улам
	<b>Дүн</b>	<b>98.3</b>			





